

а/ иргэний болон гэр бүлийн хэргийн талаар гарсан шуухийн шийдвэр мөн энэ хэргийн талаар эд хөрөнгийн холбогдолгой эвлэруулэх хэлцэлүүд;

б/ хохирол төлүүлэхтэй холбогдуулан эруугийн хэргийн талаар гаргасан таслан шийдвэрлэх тогтоол;

в/ хэрэв нэг тал нь аж ахуйн газар бол аж ахуй, худалдааны маргааны талаар гаргасан хөндлөнгийн шуухийн шийдвэр, мөн эвлэруулэх хэлцэл.

2. Хэлэлцэн Тохирогч Этгээдийн өв залгамжлах хэргийг эрхлэх байгууллагаас өөрийн улсын дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу өв залгамжлах хэргийн талаар гаргасан шийлвэр энэ зүйлийн I дэх ангид заасан шуухийн шийдвэр гэдэгт хамаарагдана.

3. Энэ зүйлийн I дэх ангийн "в"-д заасан маргааныг аж ахуйн буюу худалдааны гэж тодорхойлохдоо хөндлөнгийн шуухийн шийдвэрийг нутаг дэвсгэрт нь гуйцэтгэвэл **зохиx** Хэлэлцэн Тохирогч Этгээдийн хуулийг баримтална.

Тавин долдугаар зүйл

Шуухийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч
гуйцэтгэх урьдчилсан нөхцөл

Энэхуу Гэрээний 5б-р зүйлд дурдсан шуухийн шийдвэрийг дараах нөхцөл бүрдсэн уед хүлээн зөвшөөрч гуйцэтгэхэ:

а/ нутаг дэвсгэр дээрээ Хэлэлцэн Тохирогч Этгээдийн хуулийн дагуу гаргасан шуухийн шийдвэр хуулийн хучин төгөлдөр болж гуйцэтгэх шаардлагатай бол;

б/ нутаг дэвсгэр дээрээ Хэлэлцэн Тохирогч Этгээдийн хуулийн дагуу гаргасан шуухийн шийдвэр Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн хуулиар тэдний нутаг дэвсгэрт хүлээн зөвшөөрөгдөж гуйцэтгэгдэх буюу энэ Гэрээний ундсэн дээр тийм эрх олгогдсон бол;